



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/070/НА-СТА-ТШЗ

|   |  |
|---|--|
| <p>Цахим хуудас:<br/><a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a><br/>Сүхбаатар сум<br/>2026 он</p> | <p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх<br/>Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn<br/>Ахлах аудитор: Ц.Отгонбаяр<br/>Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn<br/>Аудитын гүйцэтгэсэн: “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар<br/>Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

Г МАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ Г  
БОЛОВСРОЛЫН ГУРАВДУГААР Г  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Г  
А.ЦЭНД-АЮУШ ТАНАА

2026.02.15 № СЭА-2026/070/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Өөрчлөлтгүй дүгнэлт Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Боловсролын яамнаас 91,409.7 мянган төгрөгийн ном сурах бичиг, гал тогооны тоног төхөөрөмжийг, Мандал сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 61,638.4 мянган төгрөгийн сурагчийн ширээ, сандал, "Спирт бал бурам" ХХК-аас 4,524.9 мянган төгрөгийн телевизор зэргийг үнэ төлбөргүйгээр хүлээлгэн өгсөн байна. Мөн аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар сургуулийн барилгад хийгдсэн 821,855.0 мянган төгрөгийн их засварыг капиталжуулан, шинээр эзэмшсэн 24092 м<sup>2</sup> хэмжээтэй 3 газрыг "Арвижих эстимейт үнэлгээ" ХХК-иар үнэлгээ хийлгэн 134,469.4 мянган төгрөгөөр бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 10 зорилтын хүрээнд 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 92.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Данс   | Балансын зүйл   | Тодруулга | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  |
|--------|---|-----------|------------------|------------------|
| 31     | МӨНГӨН ХӨРӨНГӨ  | 4         | 267,010,193.55   | 31,802,034.03    |
| 312    | Банкинд байгаа бэлэн мөнгө  |           | 267,010,193.55   | 31,802,034.03    |
| 3121   | Төгрөг  |           | 267,010,193.55   | 31,802,034.03    |
| 31211  | Төрийн сангийн харилцах   |           | 267,010,193.55   | 31,802,034.03    |
| 35     | БАРАА МАТЕРИАЛ  | 6         | 147,575,275.29   | 167,245,875.09   |
| 351    | Түүхий эд материал  |           | 70,965,197.64    | 91,680,449.44    |
| 3511   | Тусгай зориулалттай материал  |           | 70,965,197.64    | 91,680,449.44    |
| 354    | Хангамжийн материал   |           | 76,610,077.65    | 75,565,425.65    |
| 3541   | Бичиг хэргийн материал  |           | 945,250.00       | 1,740,000.00     |
| 3542   | Аж ахуйн материал   |           |                  | 1,625,300.00     |
| 3545   | Барилгын засварын материал  |           |                  | 1,568,000.00     |
| 3546   | Хүнсний материал  |           | 66,700.00        |                  |
| 3547   | Бусад хангамжийн материал   |           | 75,598,127.65    | 70,632,125.65    |
| I      | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН   |           | 414,585,468.84   | 199,047,909.12   |
| 39     | ҮНДСЭН ХӨРӨНГӨ  | 7         | 1,655,508,324.43 | 2,680,742,726.55 |
| 392    | Биет хөрөнгө  |           | 1,331,508,324.43 | 2,220,873,326.55 |
| 39201  | Барилга, байгууламж, орон сууц  |           | 867,950,789.54   | 1,689,805,821.54 |
| 39202  | Хуримтлагдсан элэгдэл   |           | (191,036,448.61) | (241,562,455.11) |
| 39205  | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     |           | 507,058,481.20   | 606,367,073.00   |
| 39206  | Хуримтлагдсан элэгдэл   |           | (90,707,470.09)  | (137,246,302.30) |
| 39207  | Тавилга, аж ахуйн эд хогшил   |           | 176,294,873.78   | 229,972,503.30   |
| 39208  | Хуримтлагдсан элэгдэл   |           | (40,971,718.42)  | (32,537,880.27)  |
| 39214  | Бусад үндсэн хөрөнгө  |           | 55,412,967.32    | 55,412,967.32    |
| 39215  | Хуримтлагдсан элэгдэл   |           | (21,798,372.24)  | (26,174,618.64)  |
| 39217  | Ном   |           | 69,305,221.95    | 76,836,217.71    |
| 393    | Биет бус хөрөнгө  |           | 324,000,000.00   | 459,869,400.00   |
| 39301  | Програм хангамж   |           | 1,705,000.00     | 1,400,000.00     |
| 39302  | Хуримтлагдсан элэгдэл   |           | (1,705,000.00)   |                  |
| 39303  | Бусад биет бус хөрөнгө  |           | 324,000,000.00   | 458,469,400.00   |
| II     | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН   |           | 1,655,508,324.43 | 2,680,742,726.55 |
| III    | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II   |           | 2,070,093,793.27 | 2,879,790,635.67 |
| 41     | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР   | 9         |                  | 1,697,000.00     |
| 413    | Өглөг   |           |                  | 1,697,000.00     |
| 4132   | Бараа үйлчилгээний зардлын өглөг                                      |           |                  | 1,697,000.00     |
| IV     | НИЙТ ӨР ТӨЛБӨР  |           |                  | 1,697,000.00     |
| 51     | Засгийн газрын хувь оролцоо   |           | 2,070,093,793.27 | 2,878,093,635.67 |
| 511    | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан |           | 869,619,679.63   | 1,002,449,079.63 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө  |           |                  |                  |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө                                 |           |                  |                  |
| 51101  | Өмч: - төрийн   |           | 869,619,679.63   | 1,002,449,079.63 |
| 512    | Хуримтлагдсан үр дүн  |           | 502,533,448.42   | 1,177,703,890.82 |
| 5121   | Өмнөх үеийн үр дүн  |           | 502,533,448.42   | 502,533,448.42   |
| 5122   | Тайлант үеийн үр дүн  |           |                  | 675,170,442.40   |
| 513    | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      |           | 697,940,665.22   | 697,940,665.22   |
| V      | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН  |           | 2,070,093,793.27 | 2,878,093,635.67 |
| VI     | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V                           |           | 2,070,093,793.27 | 2,879,790,635.67 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Данс    | Үзүүлэлт   | Тод-руулга | Өмнөх он         | Тайлант он       |
|---------|--|------------|------------------|------------------|
| 13      | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО  |            | 3,515,787,481.19 | 3,971,997,914.67 |
| 1310    | Улсын төвлөрсөн төсвөөс  |            | 3,401,390,900.00 | 3,848,916,300.00 |
| 131001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                    |            | 3,401,390,900.00 | 3,848,916,300.00 |
| 1320    | Орон нутгийн төсвөөс санхүүжих                                       |            | 114,396,581.19   | 123,081,614.67   |
| 132001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  |            | 114,396,581.19   | 123,081,614.67   |
| 12      | ТАТВАРЫН БУС ОРЛОГО  |            | 238,681,259.95   | 1,044,133,354.56 |
| 120     | Нийтлэг татварын бус орлого  |            | 238,681,259.95   | 1,044,133,354.56 |
| 120004  | Төсөв байгууллагын өөрийн орлого                                     |            | 9,002,700.00     | 1,000,000.00     |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            |            | 9,002,700.00     | 1,000,000.00     |
| 120009  | Бусад орлого   |            |                  | 1,501,470.00     |
| 120017  | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө                   |            | 214,114,430.85   | 1,020,894,752.76 |
| 120018  | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал                   |            | 15,564,129.10    | 20,737,131.80    |
| I       | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                                      | 2          | 3,754,468,741.14 | 5,016,131,269.23 |
| 21      | УРСГАЛ ЗАРДАЛ  |            | 3,680,571,869.71 | 4,289,484,352.83 |
| 210     | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                                      |            | 3,478,721,229.71 | 4,047,773,446.83 |
| 2101    | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                                    |            | 2,728,832,792.20 | 3,226,100,219.77 |
| 210101  | Үндсэн цалин   |            | 1,687,931,970.45 | 1,860,611,286.95 |
| 210102  | Нэмэгдэл   |            | 947,198,102.05   | 1,212,179,466.90 |
| 210103  | Унаа хоолны хөнгөлөлт  |            |                  | 82,938,774.00    |
| 210104  | Урамшуулал   |            | 93,702,719.70    | 70,370,691.92    |
| 2102    | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                       |            | 339,366,751.40   | 399,982,471.00   |
| 210201  | Тэтгэврийн даатгал   |            | 231,686,129.07   | 274,477,388.73   |
| 210202  | Тэтгэмжийн даатгал   |            | 27,316,840.82    | 32,346,930.24    |
| 210203  | ҮОМШӨ-ний даатгал  |            | 13,787,146.88    | 16,478,826.60    |
| 210204  | Ажилгүйдлийн даатгал   |            | 13,315,307.26    | 15,329,507.85    |
| 210205  | Эрүүл мэндийн даатгал  |            | 53,261,327.37    | 61,349,817.58    |
| 2103    | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                            |            | 86,504,681.19    | 90,311,834.67    |
| 210301  | Гэрэл, цахилгаан   |            | 12,583,410.36    | 16,920,595.63    |
| 210302  | Түлш, халаалт  |            | 64,860,550.90    | 62,968,784.04    |
| 210303  | Цэвэр, бохир ус  |            | 9,060,719.93     | 10,422,455.00    |
| 2106    | Эд хогшил, урсгал засварын зардал                                    |            | 27,041,900.00    | 31,201,780.00    |
| 210604  | Урсгал засвар  |            | 27,041,900.00    | 31,201,780.00    |
| 2108    | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж             |            | 59,857,445.50    | 58,245,345.75    |
| 210801  | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж |            | 8,495,000.00     | 2,284,200.00     |
| 210806  | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      |            | 51,362,445.50    | 55,961,145.75    |
| 2109    | Бараа үйлчилгээний бусад зардал                                      |            | 237,117,659.42   | 241,931,795.64   |
| 210901  | Бараа үйлчилгээний бусад зардал                                      |            | 87,361,906.12    | 70,594,840.00    |
| 210902  | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    |            | 31,523,200.00    | 23,434,779.00    |
| 210903  | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                                   |            | 118,232,553.30   | 147,902,176.64   |
| 213     | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   |            | 201,850,640.00   | 241,710,906.00   |
| 2132    | Бусад урсгал шилжүүлэг   |            | 201,850,640.00   | 241,710,906.00   |
| 213205  | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                             |            | 167,700,540.00   | 241,710,906.00   |
| 213209  | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              |            | 34,150,100.00    |                  |
| II      | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН  | 3          | 3,680,571,869.71 | 4,289,484,352.83 |
| III     | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)                                   |            | 73,896,871.43    | 726,646,916.40   |
| 225     | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН                                      |            |                  | 51,476,474.00    |
| 225001  | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз                                       |            |                  | 51,476,474.00    |
| IV      | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)                             |            |                  | (51,476,474.00)  |
| V       | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)  |            | 73,896,871.43    | 675,170,442.40   |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Данс    | Үзүүлэлт   | Өмнөх он         | Тайлант он       |
|---------|--|------------------|------------------|
| I       | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)                               | 3,524,790,181.19 | 3,974,499,384.67 |
| 12      | ТАТВАРЫН БУС ОРЛОГО  | 9,002,700.00     | 2,501,470.00     |
| 120     | Нийтлэг татварын бус орлого  | 9,002,700.00     | 2,501,470.00     |
| 120004  | Төсөв байгууллагын өөрийн орлого                                     | 9,002,700.00     | 1,000,000.00     |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 9,002,700.00     | 1,000,000.00     |
| 120009  | Бусад орлого   |                  | 1,501,470.00     |
| 13      | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО  | 3,515,787,481.19 | 3,971,997,914.67 |
| 1310    | Улсын төвлөрсөн төсвөөс  | 3,401,390,900.00 | 3,848,916,300.00 |
| 131001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                    | 3,401,390,900.00 | 3,848,916,300.00 |
| 1320    | Орон нутгийн төсвөөс санхүүжих                                       | 114,396,581.19   | 123,081,614.67   |
| 132001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 114,396,581.19   | 123,081,614.67   |
| II      | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)                                | 3,567,203,662.21 | 4,138,818,644.19 |
| 21      | УРСГАЛ ЗАРДАЛ  | 3,567,203,662.21 | 4,138,818,644.19 |
| 210     | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                                      | 3,365,286,322.21 | 3,898,871,438.19 |
| 2101    | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                                    | 2,728,832,792.20 | 3,226,100,219.77 |
| 210101  | Үндсэн цалин   | 1,687,931,970.45 | 1,860,611,286.95 |
| 210102  | Нэмэгдэл   | 947,198,102.05   | 1,212,179,466.90 |
| 210103  | Унаа хоолны хөнгөлөлт  |                  | 82,938,774.00    |
| 210104  | Урамшуулал   | 93,702,719.70    | 70,370,691.92    |
| 2102    | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                       | 339,366,751.40   | 399,982,471.00   |
| 210201  | Тэтгэврийн даатгал   | 231,686,129.07   | 274,477,388.73   |
| 210202  | Тэтгэмжийн даатгал   | 27,316,840.82    | 32,346,930.24    |
| 210203  | ҮОМШӨ-ний даатгал  | 13,787,146.88    | 16,478,826.60    |
| 210204  | Ажилгүйдлийн даатгал   | 13,315,307.26    | 15,329,507.85    |
| 210205  | Эрүүл мэндийн даатгал  | 53,261,327.37    | 61,349,817.58    |
| 2103    | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                            | 86,504,681.19    | 90,311,834.67    |
| 210301  | Гэрэл, цахилгаан   | 12,583,410.36    | 16,920,595.63    |
| 210302  | Түлш, халаалт  | 64,860,550.90    | 62,968,784.04    |
| 210303  | Цэвэр, бохир ус  | 9,060,719.93     | 10,422,455.00    |
| 2106    | Эд хогшил, урсгал засварын зардал                                    | 27,891,900.00    | 32,769,780.00    |
| 210604  | Урсгал засвар  | 27,891,900.00    | 32,769,780.00    |
| 2108    | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж             | 70,852,791.50    | 58,245,345.75    |
| 210801  | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,495,000.00     | 2,284,200.00     |
| 210806  | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 62,357,791.50    | 55,961,145.75    |
| 2109    | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 111,837,405.92   | 91,461,787.00    |
| 210901  | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 80,314,205.92    | 68,027,008.00    |
| 210902  | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 31,523,200.00    | 23,434,779.00    |
| 213     | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 201,917,340.00   | 239,947,206.00   |
| 2132    | Бусад урсгал шилжүүлэг   | 201,917,340.00   | 239,947,206.00   |
| 213205  | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                             | 167,767,240.00   | 239,947,206.00   |
| 213209  | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 34,150,100.00    |                  |
| III     | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)                     | (42,413,481.02)  | (164,319,259.52) |
| IV      | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)                            |                  |                  |
| V       | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)                            | 85,078,154.00    | 70,888,900.00    |
|         | Дотоод эх үүсвэрээр  | 85,078,154.00    | 70,888,900.00    |
| 222001  | Тоног төхөөрөмж  | 71,874,554.00    | 70,888,900.00    |
| 223001  | Бусад хөрөнгө  | 13,203,600.00    |                  |
| VI      | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)  | (85,078,154.00)  | (70,888,900.00)  |
| VII     | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ                      |                  |                  |
| VIII    | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)                            | (127,491,635.02) | (235,208,159.52) |
| 31      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                     |                  | 267,010,193.55   |
| 31      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                    |                  | 31,802,034.03    |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт   | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан үр дүн    | Нийт дүн                |
|-----|--|-----------------------------|---------------------------|-------------------------|-------------------------|
| 10  | <b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>869,619,679.63</b>       | <b>697,940,665.22</b>     | <b>502,533,448.42</b>   | <b>2,070,093,793.27</b> |
| 11  | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       |                             |                           |                         |                         |
| 12  | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                       |                             |                           |                         |                         |
| 13  | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 132,829,400.00              |                           |                         | 132,829,400.00          |
| 14  | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт                  |                             |                           |                         |                         |
| 15  | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    |                             |                           |                         |                         |
| 16  | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү               |                             |                           |                         |                         |
| 17  | Тайлант үеийн үр дүн                             |                             |                           | 675,170,442.40          | 675,170,442.40          |
| 19  | <b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>1,002,449,079.63</b>     | <b>697,940,665.22</b>     | <b>1,177,703,890.82</b> | <b>2,878,093,635.67</b> |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Д/Д     | Үзүүлэлт                                       | Төлөвлөгөө       | Гүйцэтгэл        | Зөрүү дүн       | Хувь  |
|---------|--|------------------|------------------|-----------------|-------|
| 1       | ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО                    | 4,244,086,100.00 | 3,971,997,914.67 | 272,088,185.33  | 93.6  |
| 131     | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                        | 4,114,533,300.00 | 3,848,916,300.00 | 265,617,000.00  | 93.5  |
| 131001  | Улсын төсвөөс санхүүжих                        | 3,856,208,700.00 | 3,848,916,300.00 | 7,292,400.00    | 99.8  |
| 131009  | Оны эхний үлдэгдлээс санхүүжих                 | 258,324,600.00   |                  | 258,324,600.00  |       |
| 132     | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                 | 129,552,800.00   | 123,081,614.67   | 6,471,185.33    | 95.0  |
| 132001  | Орон нутгийн төсвөөс                           | 129,552,800.00   | 123,081,614.67   | 6,471,185.33    | 95.0  |
| 120004  | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС          | 2,501,600.00     | 1,000,000.00     | 1,501,600.00    | 40.0  |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих      |                  | 1,000,000.00     | (1,000,000.00)  |       |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих      | 2,501,600.00     |                  | 2,501,600.00    |       |
| 1       | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                | 4,246,587,700.00 | 3,974,499,384.67 | 272,088,315.33  | 93.6  |
| 21      | УРСГАЛ ЗАРДАЛ                                  | 4,246,587,700.00 | 4,138,818,644.19 | 107,769,055.81  | 97.5  |
| 210     | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                | 3,999,348,000.00 | 3,898,871,438.19 | 100,476,561.81  | 97.5  |
| 2101    | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил              | 3,230,076,000.00 | 3,226,100,219.77 | 3,975,780.23    | 99.9  |
| 210101  | Үндсэн цалин                                   | 1,994,750,100.00 | 1,860,611,286.95 | 134,138,813.05  | 93.3  |
| 210102  | Нэмэгдэл                                       | 1,184,211,300.00 | 1,212,179,466.90 | (27,968,166.90) | 102.4 |
| 210103  | Унаа хоолны хөнгөлөлт                          |                  | 82,938,774.00    | (82,938,774.00) |       |
| 210104  | Урамшуулал                                     | 51,114,600.00    | 70,370,691.92    | (19,256,091.92) | 137.7 |
| 2102    | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 404,165,900.00   | 399,982,471.00   | 4,183,429.00    | 99.0  |
| 210201  | Тэтгэврийн даатгал                             | 274,832,800.00   | 274,477,388.73   | 355,411.27      | 99.9  |
| 210202  | Тэтгэмжийн даатгал                             | 32,333,300.00    | 32,346,930.24    | (13,630.24)     | 100.0 |
| 210203  | ҮОМШӨ-ний даатгал                              | 16,166,600.00    | 16,478,826.60    | (312,226.60)    | 101.9 |
| 210204  | Ажилгүйдлийн даатгал                           | 16,166,600.00    | 15,329,507.85    | 837,092.15      | 94.8  |
| 210205  | Эрүүл мэндийн даатгал                          | 64,666,600.00    | 61,349,817.58    | 3,316,782.42    | 94.9  |

|        |  |                  |                  |                  |       |
|--------|--|------------------|------------------|------------------|-------|
| 2103   | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                            | 96,733,300.00    | 90,311,834.67    | 6,421,465.33     | 93.4  |
| 210301 | Гэрэл, цахилгаан   | 17,730,500.00    | 16,920,595.63    | 809,904.37       | 95.4  |
| 210302 | Түлш, халаалт  | 68,000,000.00    | 62,968,784.04    | 5,031,215.96     | 92.6  |
| 210303 | Цэвэр, бохир ус  | 11,002,800.00    | 10,422,455.00    | 580,345.00       | 94.7  |
| 2106   | Эд хогшил, урсгал засварын зардал                                    | 32,819,500.00    | 32,769,780.00    | 49,720.00        | 99.9  |
| 210604 | Урсгал засвар  | 32,819,500.00    | 32,769,780.00    | 49,720.00        | 99.9  |
| 2108   | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж             | 71,289,800.00    | 58,245,345.75    | 13,044,454.25    | 81.7  |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,284,200.00     | 2,284,200.00     |                  | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 69,005,600.00    | 55,961,145.75    | 13,044,454.25    | 81.1  |
| 2109   | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 164,263,500.00   | 91,461,787.00    | 72,801,713.00    | 55.7  |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 140,828,700.00   | 68,027,008.00    | 72,801,692.00    | 48.3  |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 23,434,800.00    | 23,434,779.00    | 21.00            | 100.0 |
| 213    | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 247,239,700.00   | 239,947,206.00   | 7,292,494.00     | 97.1  |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг   | 247,239,700.00   | 239,947,206.00   | 7,292,494.00     | 97.1  |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                             | 247,239,700.00   | 239,947,206.00   | 7,292,494.00     | 97.1  |
| 22     | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   |                  | 70,888,900.00    | (70,888,900.00)  |       |
|        | Дотоод эх үүсвэрээр  |                  | 70,888,900.00    | (70,888,900.00)  |       |
| 222001 | Тоног төхөөрөмж  |                  | 70,888,900.00    | (70,888,900.00)  |       |
| 2      | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН  | 4,246,587,700.00 | 4,209,707,544.19 | 36,880,155.81    | 99.1  |
| 31     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                     |                  | 267,010,193.55   | (267,010,193.55) |       |
| 31     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                    |                  | 31,802,034.03    | (31,802,034.03)  |       |
| 1      | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ                                     |                  |                  |                  |       |
| 2      | БАЙГУУЛЛАГЫН ТОО   | 1                | 1                |                  | 100.0 |
| 3      | Төсвийн байгууллага  | 1                | 1                |                  | 100.0 |
| 5      | АЖИЛЛАГСАДЫН ТОО   |                  |                  |                  |       |
| 6      | Удирдах ажилтан  | 1                | 1                |                  | 100.0 |
| 7      | Гүйцэтгэх ажилтан  | 77               | 77               |                  | 100.0 |
| 8      | Үйлчлэх ажилтан  | 22               | 22               |                  | 100.0 |
| 11     | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД                            | 1,520            | 1,520            |                  | 100.0 |
| 24     | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ  |                  |                  |                  |       |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1,153,631.4 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Тайлант онд нэмэгдсэн газрыг үнэлгээ хийлгэн бүртгэхдээ газрын үнэлгээний нэгж үнийг буруу сонгосноор 331,776.4 мянган төгрөгөөр дутуу тусгасан,
- Тайлант онд хөрөнгө оруулалтаар хийгдсэн 821,855.0 мянган төгрөгийн сургуулийн барилгын их засварыг капиталжуулалгүйгээр тусдаа 1 хөрөнгө мэтээр бүртгэсэн,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга”-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг

үнэн зөв толилуулах ёстой...”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **3,720.4** мянган төгрөгийн 3 зөрчил<sup>1</sup> илэрч төлбөрийн акт тогтоолоо.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **3,720.4** мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 33,085.3 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

1. Хоол зүйч Т.Мөнхгэрэлд тогоочийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 20 хувиар тооцож 1,173.7 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 6 дахь “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдлийг зөвхөн тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа хугацаанд нь олгоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, сум, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 8 багшид тус бүр 15.0-20.0 хувиар тооцон 938.6 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь”, “сумын түвшинд 15 хувь”, “аймгийн түвшинд 20 хувь” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Тооцооллын алдаанаас шалтгаалж захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Алтантуяад цалингийн шатлал буруу сонгосноос 795.3 мянган төгрөгийг, дээд шатны захирагчийн шийдвэргүйгээр 812.8 мянган төгрөгийн нийт 1,608.1 мянган төгрөгийн илүү цагийн хөлс тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөрчлийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга   | Нийт алдаа |                    | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |                    | Үүнээс     |                    |              |     | Зөвлөмж |     |
|---|------------|--------------------|-----------------------------------|-----|--------------------------|--------------------|------------|--------------------|--------------|-----|---------|-----|
|   | Тоо        | Дүн                | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн                | Залруулсан |                    | Залруулаагүй |     | Тоо     | Дүн |
|   |            |                    |                                   |     |                          |                    | Тоо        | Дүн                | Тоо          | Дүн |         |     |
| Газрыг бүртгэхдээ 331,776.4 мянган төгрөгөөр дутуу тусгасан                 | 1          | 331,776.4          |                                   |     | 1                        | 331,776.4          | 1          | 331,776.4          |              |     |         |     |
| Барилгын их засварыг капиталжуулалгүйгээр тусдаа 1 хөрөнгө мэтээр бүртгэсэн | 1          | 821,855.0          |                                   |     | 1                        | 821,855.0          | 1          | 821,855.0          |              |     |         |     |
| <b>Дүн</b>  | <b>2</b>   | <b>1,153,631.4</b> |                                   |     | <b>2</b>                 | <b>1,153,631.4</b> | <b>2</b>   | <b>1,153,631.4</b> |              |     |         |     |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |                | Үүнээс        |                |                 |     |         |     |                                      |     |   |     |
|---|-------------|----------------|---------------|----------------|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|-----|---|-----|
|   |             |                | Төлбөрийн акт |                | Албан шаардлага |     | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|   | Тоо         | Дүн            | Тоо           | Дүн            | Тоо             | Дүн | Тоо     | Дүн | Тоо                                  | Дүн | Тоо   | Дүн |
| Хоол зүйчд тогоочийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгосон                                      | 1           | 1,173.7        | 1             | 1,173.7        |                 |     |         |     |                                      |     |   |     |
| Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, нотлох баримтгүйгээр илүү олгосон | 1           | 938.6          | 1             | 938.6          |                 |     |         |     |                                      |     |   |     |
| Тооцооллын алдаанаас шалтгаалж цалин илүү тооцож олгосон.                                     | 1           | 1,608.1        | 1             | 1,608.1        |                 |     |         |     |                                      |     |   |     |
| <b>Дүн</b>  | <b>3</b>    | <b>3,720.4</b> | <b>3</b>      | <b>3,720.4</b> |                 |     |         |     |                                      |     |   |     |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|  |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|  | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил         |             |     |               |     |                 |     |         |     |
| Шилэн дансанд мэдээлбэл зохих 171 мэдээллээс 3 хугацаа хоцроосон | 1           | -   |               |     |                 |     | 1       | -   |
| Дүн  | 1           | -   |               |     |                 |     | 1       | -   |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой           |             |     |               |     |                 |     |         |     |
|  |             |     |               |     |                 |     |         |     |
| Дүн  |             |     |               |     |                 |     |         |     |
| Нийт дүн   |             |     |               |     |                 |     |         |     |

## ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Зөрчилгүй               | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                            |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1 | ТШЗ                         | 1                        | 1                           |                    |                 | 1                       |                |       |                            |
| 2 | Төсөл, хөтөлбөр             |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 3 | ЗГТС                        |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 4 | ТТЗ                         |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
| 5 | ТЕЗ                         |                          |                             |                    |                 |                         |                |       |                            |
|   | <b>НИЙТ</b>                 | <b>1</b>                 | <b>1</b>                    |                    |                 | <b>1</b>                |                |       |                            |